

АРВИЖИХ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ПРОТКОЛ

2015 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

Арвижих ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2015 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр 17 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо Жамъян гүний гудамж-12, Олимпийн гудамж 3, Гранд оффисийн 3 давхарт 36 тоот 17⁰⁰ цагт хурлын танхимд хуралдав.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын даргаар Дамбий овогтой Баатар, Хурал зохион байгуулах комиссийн дарга Б.Эрдэнэбат, комиссийн нарийн бичгийн даргаар Ш.Уянга, Тооллогын комисс Б.Энхбат, Г.Баясгалан нар хурлыг зохион байгуулж хуралдуулав.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцсэн асуудлууд:

- Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ын дүгнэлтийг хэлэлцэж батлах
- Компанийн 2015 оны бизнесийн үйл ажиллагааны төлөвлөгөө
- ТУЗ-ын гишүүдийн болон аудитын, цалин, урамшууллын, нэр дэвшүүлэх хороодын ажлын тайланг хэлэлцэх

Хурлын бүртгэл 16.30-17.00 явагдаж, хурал 17 цагаас эхэлж Тооллогын комиссийн дарга Б.Энхбат хурлын ирцийг танилцуулав.

Ш.Уянга хэлсэн нь:

Сайн байцгаана уу, Хувьцаа эзэмшигч та бүхэнд хурлын дэгийн дагуу хурлын ирцийг танилцуулъя. 2015 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн Арвижих ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд Хувьцаа эзэмшигч Б.Содбаяр, Ви Эм Ви ХХК/регистрийн дугаар 5152399/-ийг төлөөлж Ө.Оюун Эрдэнэ, Д. Дорлигжав /саналын хуудсаар саналаа ирүүлсэн/, Тулгат чандмань баян БДК-ийн Батсайхан нарын ирцтэйгээр нийт саналын эрхтэй хувьцааны 94.5 хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигч нар хуралд оролцсноор Компанийн тухай хуулийн 69.1-д заасныг үндэслэн хурлыг хүчин төгөлдөр болсон гэж үзэж байна.

17 цаг 05 минут Хурлын нээлтийг хурлыг даргалж Д.Баатар хийв.

Хурлын дарга Д.Баатар:

Сайн байцгаана уу, Хувьцаа эзэмшигч та бүхнийг хуралдаа идэвхтэй оролцож байгаад талархал илэрхийлье.

1. Хэлэлцэх асуудал: Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ын дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай.

Арвижих ХК-ийн үйл ажиллагааны талаар танилцуулъя.

Тус компаний Улаанбаатар хотын Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт буй хүнсний ногоо хадгалах зоорийн барилга байгууламж нь 1960-аад оны үед ашиглалтанд орж хүнсний ногоо хадгалах улсын том зоориор үйл ажиллагаагаа явуулж байсан.

1996 онд хувьчлагдан 56381 ширхэг энгийн хувьцааг гарган “Арвижих” ХК болон өөрчлөгдсөн. Компани сүүлийн жилүүдэд тогтвортой үйл ажиллагаа явуулж чадаагүй ашиггүй ажиллаж байгаа бөгөөд энэ нь дараах хүчин зүйлээс шалтгаалсан гэж үзэж байна. Анх нийт 22 зоорь байснаас 9 зоорь зарагдаж одоо байгаа нь 13 зоорийн барилга байгууламж байгаа.

2008 онд Арвижих ХК-ийг одоогийн удирдлагууд хүлээн авахад тус зоорийн барилгууд маш их муудаж хуучирсан, дээвэр болон хашаа нь эвдэрч нурсан хүнсний ногоо хадгалах наад захын эрүүл ахуйн шаардлагуудыг хангахааргүй болсон байсан.

2. Баянзүрх дүүрэг, Сонгинохайрхан дүүргийн Толгойт гэсэн гол баруун болон зүүн нутгийн гарцуудын ойролцоо орчин үеийн шинэ технологиор баригдсан жилийн 4 улиралд ашиглагдах бүрэн боломжтой хүнсний ногоо хадгалах зоориуд ажиллаж байгаа мөн хүнсний ногоо тариалагч компаниуд өөрийн зоорь агуулах, хүлэмжтэй болсон нь зах зээлийн эрэлтийг бууралж байна.

Цаашид тогтвортой үйл ажиллагаа явуулахад ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалтийг хийх шаардлагатай байна.

Санхүүгийн тайлангийн талаар танилцуулъя.

2014 онд үйл ажиллагаа зогсонг байснаас орлого олоогүй, газрын төлбөр болон харуул хамгаалалтын зардал, цахилгааны зардал зэрэг тогтмол зардлууд гарсан байгаа.

Д.Баатар:

2. Хэлэлцэх асуудал: Компанийн 2015 оны бизнесийн үйл ажиллагааны төлөвлөгөөний тухай

Дээр танилцуулсны дагуу тогтвортой үйл ажиллагаа явуулахад хөрөнгө, мөнгөний шаардлага их байгаа, дээр нь улс орны эдийн засаг хүндрэлтэй байгаа ийм нөхцөлд хөрөнгө оруулалт олох нь их хүндрэлт байна.

3. Хэлэлцэх асуудал: ТУЗ-ын гишүүдийн болон аудитын, цалин, урамшууллын, нэр дэвшүүлэх хороодын ажлын тайланг хэлэлцэх

Бид дараагийн хурлын дэгдээ орцгооё. Асуулт хариулт, санал шүүмжлэл хэсэгт шилжүүлий.

Тулгат чандмань баян ҮЦК-ийн Улаанбаатар дах салбарын захирал Батсайхан:

Асуулт: Компани сүүлийн дараалсан жилүүдэд үйл ажиллагаа муу явуулж байна. Үүндээр удирдлагууд хэр анхаарч ажиллаж байна вэ

Хариулт Д.Баатар: Дээр компанийн байдлыг танилцуулсан, зах зээлд гарахын тулд компанийн зоорин байгууламжууд болон орчины зам зэргийг засварлахад мэдээж их хэмжээний хөрөнгө буюу хөрөнгө оруулалтын асуудалтай тулгарч байна. Иймд бид шинээр сайжруулах төсөл боловсруулж хөрөнгө оруулалтыг давхар судалж байна.

Өөр асуулт хариулт, санал шүүмж байхгүй бол саналаа хураацгаая.

Санал өгөх журмыг Тооллогын комиссоос танилцуулна.

Ш.Уянга: Ээлжит хурлын хэлцсэн асуудлуудад санал өгөхдөө зөвшөөрсөн, татгалзсан, түдгэлзсэн гэсэн хариултын аль санал өгөх хэсгийн доор чантлана.

Эхлээд Компанийн 2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хангалттай эсвэл хангалтгүй тал дээр санал өгцгөөе

Компанийн 2015 оны бизнесийн үйл ажиллагааны төлөвлөгөөний талаар санал өгье, сүүлийн асуудал ТУЗ-ын гишүүдийн болон аудитын, цалин, урамшууллын, нэр дэвшүүлэх хороодын ажлын тайланг хэлэлцэх талаар зөвшөөрч байгаа бол зөвшөөрсөн хэсгийн доор санал өгөх хэсгийн доор чантлана.

Түр завсарлаад тооллогын комиссийн дүнг танилцуулна

Завсарлагаа

15 минутын дараа:

Тооллогын комисс Б.Энхбат: Тооллогын дүнг танилцуулъя

№	Санал асуулга	Хувь	Хувьцааны эрхийн тоо
1	Компанийн 2011 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан хангалттай	94.5 хувь	
2	Компанийн 2015 оны бизнесийн үйл ажиллагааны төлөвлөгөө	94.5 хувь	
3	ТУЗ-ын гишүүдийн болон аудитын, цалин, урамшууллын, нэр дэвшүүлэх хороодын ажлын тайланг хэлэлцэх	94.5 хувь	

Хурлаас гаргасан шийдвэрийг танилцуулья

1. Компанийн 2014 оны санхүүгийн үйл ажиллагааны тухай ТУЗ-ийн гүйцэтгэх удирдлагын гаргасан тайланг хангалттай гэж үзсүгэй.
 2. 2015 онд компанийн бизнесийн үйл ажиллагааг сэргээх боломж бололцоог судалж төлөвлөгөө боловсруулан баталсугай.
 3. Компанийн 2014 оны ТУЗ-ын гишүүдийн болон аудитын, цалин, урамшууллын, нэр дэвшүүлэх хороодын ажлын тайланг хангалттай гэж үзсүгэй.
- ТУЗ-ийн дарга Баатар хурлыг хаана.

2015 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хүрэлцэн ирж оролцсонд та бүхэнд талархаж байна. Бид компанийн үйл ажиллагааг сайжруулах төслийг боловсруулан хөрөнгө оруулалтыг судлан ажиллана.

Хурлын протокол хөтөлсөн:



Г.Баясгалан